

**2019 ОНЫ 10 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДРИЙН  
ШУУРХАЙ ХУРЛААС ӨГСӨН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ**

2019.10.20

№28

Дархан

<b>№</b>	<b>Үүрэг даалгавар</b>	<b>Хариуцсан хэлтэс</b>	<b>Гүйцэтгэл</b>
1.	Авилгатай тэмцэх газрын ажлын хэсэг ирэхтэй холбогдуулан бүгд өөр өөрийн чиглэлээр бэлтгэл хангах	Бүгд	<p>Худалдан авах ажиллагаа, төрийн үйлчилгээний нээлттэй ил тод байдал, сахилга ёс зүйн асуудал, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хүний нөөцийн асуудал зэрэг асуудалтай холбоотой холбогдох баримт бичгүүдэд хяналт хийж бүрдлийг хангаж байна.</p> <p>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн удирдамжаар мэдээ бэлтгэн иргэд олон нийтэд сурталчилсан.</p> <p>Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ээс ирүүлсэн авлигаас урьдчилан сэргийлэх шторкуудыг /9 ш/ орон нутгийн телевизүүд болон darkhan.gov.mn цахим хуудас, Дархан-Уул аймаг, Дархан хот, Дарханы мэдээ сошил сувгууд, Лэд дэлгэцээр нэвтрүүлж байна.</p>
2.	Боловсролын байгууллагуудын талаар мэдээлэл бэлтгэж өгөх хэрэгтэй байна. Эвдрэл гэмтэл гарах болзошгүй гэсэн жагсаалттай болмоор байна. Энэ онд 9 дүгээр сургуулийг 3 удаа заслаа. Эвдрэл гарсан хойно нь гал унтраах зорилгоор ажилладаг бус эвдрэлийг урьдчилсан тооцоолдог больё	ЗАА	<p>БСУГ инженерийн шугам сүлжээний насжилтын судалгааг гаргаж, засварлаж шинэчлэх шаардлагатай гэсэн жагсаалт ирүүлсний дагуу мэргэжлийн байгууллагатай хамтарсан үзлэг хийж, шаардлагатай төсөв тооцоог хийхээр болсон. Энэ талаар Засаг даргын орлогч А.Түвшинбат даргатай ярьсан. БСУГ-т үүрэг чиглэл өгч судалгааг гаргуулах болсон.</p>
3.	Мэдээлэл холбооны Алтантуяагаас ирсэн бичгийг ХОХБТХ-ээс авч үзэх. Хамгаалалтын зурvas газрын захирамжийг ойрын хугацаанд гаргах. Хэдэн жилийн өмнө шороо ухаж явсан машин очиж шугам тасалснаас болж 7 хоног орчим мэдээлэл, сүлжээ доголдож байсан. Анхаарч ажиллах	ЗАА	<p>Цахилгаан холбооноос ХОХБТХ-ирсэн бичгийг ГХБХБГ-руу шилжүүлсэн мэргэжилтэн Батчулуун захирамжийн төслийг гаргаж зуруулна.</p>
4.	НААҮГ-ын зохион байгуулалтыг өөрчлөх асуудал ямар шатандaa явагдаж байгаа вэ?	ЗАА	<p>Монгол Улсын Их Хурлын 2018 оны 80 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 23-ны 4-1/7297 дугаартай албан бичгийн хүрээнд Төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан орон</p>

			<p>нутгийн өмчийн ашиглалтыг сайжруулах, төсвийн үр ашиг, сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр Нийтийн аж ахуй үйлчилгээний газрыг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын зарчмаар ажиллуулах асуудлыг судалж, бэлтгэл ажлыг хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн хурлын /2019.10.15/ товыг гишүүдэд зарлаж бэлтгэл ажлыг хангасан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тус ажлын хэсэг хуралдан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Өмч төсөв, санхүү эдийн засаг, гадаад бодлогын хяналтын хороотой хамтран ажиллах хүсэлтэй байгаа зохих шийдвэрийг гаргаж өгөх тухай албан бичгийг /Ажлын хэсгийн ахлагчийн гарын үсэгтэй Т.Ганболд/ аймгийн Иргэдийн Хурлын дарга Г.Эрдэнэбатад хүргүүлсэн.</li> </ul>
5.	Замчин худалдааны төвд дулааны асуудал гардаг. Тэнд сууж байгаа ахмадууд өөрсдөө төлсөн байдаг. Энэ асуудлыг шийдэж өгөөч	ЗАА	“ДДС” ТӨХК-нд албан тоот өгсөн хариу ирээгүй байна.
6.	24 дүгээр цэцэрлэгийн өргөтгөл гээд дулааныг хаасан байгаа. Энэ асуудлыг анхаарах. Хэд хоног хичээл сургуулийг завсардуулах вэ?	ЗАА НБХ	Өргөтгөлийн дулааны шугам холбох ажил хийгдэж байгаа тул дулаан хаагдсан. Уг ажил 26-нд дуусаж 24-р цэцэрлэгт дулаан өгнө.
7.	АТГ-аас ажлын хэсэг ирнэ. Хөрөнгө оруулалт, худалдан авахтай холбоотой ажлуудыг үзэж байгаа. Удирдамж ирээгүй байгаа. Зөвлөмжийн гүйцэтгэл гэж хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Хугацаанд нь хариуг нь хүргүүлээрэй.	ХЭЗХ	Зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь хүргүүлсэн. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн удирдамжаар мэдээ бэлтгэн иргэд олон нийтэд сурталчилсан. Удирдамжийг төрийн байгууллагууд болон хэлтсүүдэд хүргүүлж бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргасан.
8.	28 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийг АТГ-аас дуудсан. Шинэ цэцэрлэг, шинэ удирдлага туршлагагүйн улмаас эцэг эхчүүдээс хандив авсан. Төсвийн тухай хууль, боловсролын тухай хуулийг зөрчсөн.	НБХ	Дархан-Уул аймгийн сургууль цэцэрлэгийг хөгжүүлэх сангийн журмыг боловсруулсан

	Энэ хүмүүсээ сургах хэрэг байна.		
9.	Спорт цогцолборын санхүүжилт хангалтгүй байна. 1,8 тэрбумын санхүүжилт орж ирсэн бол ажил нэлээд явах байлаа. Одоо гүйцэтгэлээр 200-аад сая төгрөгийн ажил хийгдсэн. Гадна фасадны материал Эрээн дээр гацсан. 500 сая төгрөг байвал материалыа авах гээд байгаа. П.Батсүх үүнийг хөөцөлдмөөр байна. Гадна фасадаа хийчихвэл гадна ажил явна.	ХОХБТХ	
10.	Үйлдвэрийн районд байгаа Чуан Руан гээд Хятад компанийн тухай гомдол тасрахгүй байна. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бол манай улсын хууль, журмыг мөрдөх ёстой. Тамхины тухай хууль, Татварын тухай хууль, Зөрчлийн тухай хууль зэрэг хэд хэдэн хуулийг зөрчиж байгаа талаар иргэдээс мэдээлэл ирүүлсэн. Л.Алтанчимэг дарга өөрөө ахлаад ажлын хэсгийн удирдамжаа надаар батлуулаад хяналт шалгалтын ажлыг яаралтай явуулах шаардлагатай байна. ЦГ, МХГ, гадаадын иргэн харьяатын албыг заавал байлцуулах.	ХЭЗХ	ХХҮГ-т НХХЯ-аас удирдамж ирсэн. Энэ удирдамжийн дагуу гадаадын иргэн харьяатын албаны ахлах байцаагч явж шалгахаар болсон.
11.	Галт зэвсгийн тооллого хангалтгүй байна. Мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээллэх.	ХЭЗХ МТА	Цагдаагийн газраас “Галт зэвсэг-2019” тооллого бүртгэлийг эхлүүлсэнтэй холбогдуулан хэсгийн байцаагч нартай баг хариуцсан байцаагч нар хамтран ажиллаж, бүртгэл, хөдөлгөөн, татварт хамруулалтыг анхаарч, өдөр бүр хуваарь гарган цагдаагийн газрын 201 тоот өрөөнд ээлжлэн сууж бүртгэлийг шинэчлэх, гэрчилгээг хуулбарлах, утас, мэдээллийг өөрчлөх, татвар ногдуулан хураах, ТУАБ-р нэхэмжлэл үүсгэх ажлуудыг зохион байгуулсан. 2019.10.21 өдөр Цагдаагийн газар дээр дахин

			<p>уулзалт хийн хэсгийн байцаагч нарын хамт гэрээр нь очиж биеэр болон нүдээр буртгэл, татварт хамруулалтаа хийхээр болж ажиллагааг явуулж байна. ТУНС-д нийт галт зэвсгийн 45 хувийг ногдол үүсгээд байна.</p> <p>Галт зэвсгийн тооллогод хамрагдах тухай мэдээ бэлтгэж, орон нутгийн телевизүүд болон darkhan.gov.mn цахим хуудас, Дархан-Уул аймаг, Дархан хот, Дарханы мэдээ сошил сувгуудаар нэвтрүүлж байна. Зэвсгийн тооллого 78 гаруй хувьтай үргэлжилж байна.</p>
12.	ЭЕШ-тай холбоотой бэлтгэл ажлыг хангуулах. 2018-2019 оны хичээлийн жилд давтлага явагдаагүй. Үүнээс үүдэн аймгийн дундаж оноо 8 дугаар байранд эрэмбэлэгдсэн. Түүхэндээ ийм доор үнэлэгдэж байгаагүй. Системтэй ажил зохион байгуульяа. Ц.Баттогтох, ОИЦ сургуулийн Баярсайхан гээд сайн багш нар байгаа. Нийлээд арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай байна.	НБХ	<p>Тэргүүлэх зэргээс дээш зэрэгтэй багш нараас бүрдсэн чадварлаг багийг байгуулсан. Бусад гишүүд багш нарыг арга зүй, онол, шинжээчдийн багт хувааж чиглэл тус бүрээр сургалтыг зохион байгуулна. Сургууль тус бүрээр төгсөх ангийн сурагчид, эцэг эхчүүд багш наарт өнгөрсөн хичээлийн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтын талаар танилцуулга хийж, хүүхэд бүрээр шалгалт өгөх судлагдахуун тус бүрээр гаргаж эхэлсэн.</p>
13.	2019 оны эхээр Татварын хэлтэст аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа дугуй засвар, авто засвар, үсчин зэрэг үйлчилгээний байгууллагад зураг авалтаар явах үүрэг даалгавар өгсөн захирамж гарсан. Хэрэгжилтийг тооцох хугацаа болж байгаа. Тайлангаа бэлтгээрэй. Энэ байгууллагууд НӨАТ-ын тухай хуулийг зөрчиж иргэнд нэг ч баримт олгохгүй байна. Далд эдийн засаг бий болгоод байна. СТСХ ажлаа шахаад яваарай.	СТСХ	<p>НӨАТУС-ийн хууль 2016 оноос эхлэн хэрэгжиж эхэлснээр ибаримт олголтын хяналтыг байнга хийж байгаа. 2019 оны эхээр аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа дугуй засвар, авто засвар, үсчин зэрэг үйлчилгээний байгууллагад зураг авалтаар явах үүрэг даалгавар өгсөн захирамж гарсан Гэхдээ зөвхөн энэ төрлийн үйл ажиллагааг эрхэлдэг бус бараа ажил үйлчилгээ борлуулж л байвал ибаримт олгохыг шаардсан ажлын хэсгийг 8 багаар сегментчилээд татварын албаны бүх байцаагч нарын бүрэлдэхүүнтэй гадуур явж байгаа.</p>
14.	22 дугаар цэцэрлэгт гарсан нөхцөл байдлын талаар мэргэжлийн байгууллагын эцсийн	НБХ	<p>Хоолны дээж, хүнсний бүтээгдэхүүнд агаар орчны арчиасын шинжилгээнд үүсгэгч нян илрээгүй байна. /МХГазар/</p>

	дүгнэлтийг танилцуулах. Хоол талаасаа асуудал үүссэн эсэхийг тодорхой болгох		
15.	Өөрийн гэсэн орон байргүй албан хаагчдын судалгааг гаргаж танилцуулах	Эцэг эхийн зөвлөлийн нарийн бичгийн дарга О.Мөнхсүрэн	<p>Дархан-Уул аймгийн ЗДТГазрын даргын 2019 оны 2-A/67 дугаар тушаалаар байгуулагдсан “Эцэг эхийн зөвлөл”-ийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Залуу болон анхаарал шаардлагатай гэр бүлд дэмжлэг үзүүлэхэд хамтран ажиллах” арга хэмжээний хүрээнд зөвлөл хуралдаж гарсан шийдвэр, хурлын тэмдэглэлийг аймгийн Засаг даргын орлогч (А.Түвшинбат)-д 2019.10.11-ны өдөр танилцуулж, өөрийн гэсэн байргүй, өрх толгойлсон, бага насны 2 хүүхэдтэй НҮА-ны үйлчлэгч О.Мөнхтуяаг түрээсийн байртай болоход нь дэмжлэг үзүүлэхээр аймгийн ОНӨГ-ын ахлах мэргэжилтэн М.Хүрэлбаатар, мэргэжилтэн Одгэрэл нарт албан ёсоор танилцуулсан. Түрээсийн байраар төрийн албан хаагчдыг хангахад эхний ээлжинд анхаарч ажиллахаа мэдэгдсэн болно.</p> <p>Аймгийн ЗДТГ-ын албан хаагчдын орон байртай эсэх судалгааг ТЗУХ-ийн хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн А.Лхагважаргал (<i>төрийн албаны зөвлөл дээр ажлын хэсгийн хамт ажиллаж байсан учир утсаар 2019.10.25-ны өдрийн 10.38 цагт</i>)-аас тодруулахад бүх албан хаагчид өөрийн гэсэн орон сууц, байшин, түрээсийн байртай гэсэн хариултыг өгсөн.</p>
16.	2020 оныг ажлын байрыг нэмэгдүүлэх жил болгон зарлах гэж байна. ХХҮГ үүн дээр зорилтот сегментээ тодорхойлох хэрэгтэй байна. Судалгаатай байх шаардлагатай	НБХ	<p>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 159 дүгээр тогтоолоор баталсан “Ажилгүйдэл ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, Дархан-Уул аймгийн ИТХ, ЗДТГ-аас 2020 оныг “Ажлын байрыг нэмэгдүүлэх жил” болгон зарлахтай холбогдуулах дараах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>“Ажлын байрыг нэмэгдүүлэх” аймгийн хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрийн хүрээнд;</li> <li>Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа /2017-2020/, МБСБ-уудын аймгийн</li> </ol>

			<p>салбар зөвлөлийн төлөвлөгөөг үндэслэн ЕБС-ийн 9,12-р ангийн төгсөгчдийг АМЧБО сургалтад хамруулах, Дархан-Уул аймгийн Их дээд сургууль, МБСБ-уудад суралцуулах, үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран төгсөгчдийг ажлын байраар хангах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх</p> <p>3 Дархан-Уул аймгийн ажилгүй 10000 гаруй иргэдийн судалгааг хийж Зорилтот бүлэгт нь тохирсон төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангах, ажилгүйдлийг бууруулах</p> <p>4 Аймгийн дэд хөтөлбөрүүд, СХС, ЖДҮХС, арилжааны банкуудын зээлүүд, Улсын болон орон нутгийн байгууллагуудын гүйцэтгэх бүтээн байгуулалтын хүрээнд тус тус бий болсон шинэ ажлын байруудыг бүртгэх</p>
--	--	--	--

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

П.БАЯРСАЙХАН

НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН:

Ц.БОЛОРТУУЛ